



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Зохицуулагч нарт хангалт олгох
тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, Монгол Улсын Шадар Сайдын 2020 оны “Стратеги, төлөвлөгөө батлах тухай” 26 дугаар тушаалын 3.9.4, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн №730, 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн №785, Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны 17 дугаар хурлын шийдвэрийг хэрэгжүүлж бүх нийтийн бэлэн байдлын зэрэг тогтоосон өдрүүдэд хэв журам сахиулахаар “Зохицуулагч”-аар томилогдсон Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа салбар, нэгжийн ажилтнуудад хуваарьт өдрүүдэд өдөрт нэг удаа халуун хоол, цай, амны хаалт, гар ариутгагчаар тус тус хангах, хуваарилах, хүргэх, бүртгэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Захиргаа, хүний нөөцийн газар /Р.Амарбаясгалан/, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс /С.Батхуяг/-т, зохицуулагч нарын зохион байгуулалтад үйлчлэх тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба /Б.Батбаатар/-нд тус тус үүрэг болгосугай.

2. Дээрх арга хэмжээнд гарах зардлыг төсөвлөн зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар /Б.Батхишиг/-т зөвшөөрсүгэй.

3. Зохицуулагчийн үүрэгт ажлыг эрх бүхий байгууллагаас гаргасан зөвлөмж, зааварчилгааны дагуу хариуцлагатай, сахилга баттай гүйцэтгэх, цагдаагийн байгууллагын ажилтны тавьсан хууль ёсны шаардлагыг хэрэгжүүлж ажиллахыг зохицуулагчаар томилогдсон ажилтнуудад даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн Гамшгаас хамгаалах штаб /П.Гантөгс/-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ